

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 05 сарын 06 өдрийн
16 тоот тогтоолын хавсралт

ЗАХ ЗЭЭЛ ҮҮСГЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

(Шинэчилсэн найруулга)

*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 22
дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан./*

Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам

Нэг. Нийтлэг үндэслэл.....	2
Хоёр. Зах зээл үүсгэгчид тавих шалгуур, шаардлага.....	2
Гурав. Зах зээл үүсгэгчээр бүртгүүлэх.....	3
Дөрөв. Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа.....	4
Тав. Зах зээл үүсгэх гэрээг түдгэлзүүлэх, цуцлах.....	5
Зургаа. Онцгой нөхцөл байдал.....	6
Долоо. Зах зээл үүсгэгчийн үүргийн хэрэгжилтийг үнэлэх, арилжааны шимтгэлийн хөнгөлөлт олгох.....	7
Найм. Хариуцлага.....	8
Хавсралт 1.....	9
Хавсралт 2.....	10
Хавсралт 3.....	13
Хавсралт 4.....	14

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН
ЗАХ ЗЭЭЛ ҮҮСГЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Бирж” гэх)-д зах зээл үүсгэгчийг бүртгэх, гэрээ байгуулах, зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тодорхойлох, хяналт тавих, хариуцлага хүлээлгэх, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулна.
- 1.2 Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа гэж үнэт цаасны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор тодорхой үнэт цаас худалдах, худалдан авах үнийн саналыг энэхүү журамд заасан нөхцөлийн дагуу нэгэн зэрэг гаргах замаар арилжаанд оролцох ажиллагааг хэлнэ.
- 1.3 Биржид бүртгэлтэй хувьцаа, өрийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгслийн хоёрдогч зах зээлийн арилжаанд зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 1.4 Журамд хоёрдмол утга гарсан тохиолдолд үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомж, түүний үзэл баримтлал, зарчимд нийцүүлэн журмыг тайлбарлана.

Хоёр. Зах зээл үүсгэгчид тавих шалгуур, шаардлага

- 2.1. Дараах этгээд зах зээл үүсгэгчээр бүртгүүлэхээр Биржид хүсэлт гаргаж болно:
 - 2.1.1. Дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй Биржийн гишүүн үнэт цаасны компани;
 - 2.1.2. Үнэт цаасны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан Хөрөнгө оруулалтын сан (цаашид “ХОС” гэх);
/Энэ заалтад Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 22 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./
 - 2.1.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 18.4-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-с баталсан жагсаалтад багтсан биржийн гишүүн хуулийн этгээд.
- 2.2. Зах зээл үүсгэгч гэж зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа явуулахаар Биржид бүртгүүлэн, Биржтэй “Зах зээл үүсгэх гэрээ” байгуулсан, энэхүү журмын 2.1-т заасан этгээдийг ойлгоно.
- 2.3. Энэхүү журмын 2.1.2 болон 2.1.3-т заасан этгээд нь зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааг биржийн гишүүн үнэт цаасны компанитай гэрээ байгуулж, зөвхөн зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанд ашиглах тусгайлсан дансаар дамжуулан гүйцэтгэнэ. Тус гэрээнд зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцаанд талуудын хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой тусгасан байна.
- 2.4. Энэхүү журмын 2.3-т заасны дагуу гэрээ байгуулснаас үл хамааран зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаатай холбоотойгоор энэхүү журам, болон “Зах зээл үүсгэх гэрээ”-ний үүргийн биелэлт, болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо, Биржийн дүрэм, журмын хэрэгжилтийг Зах зээл үүсгэгч хариуцна.
- 2.5. Энэхүү журмын 2.1.2 болон 2.1.3-т заасан этгээд болон түүнтэй гэрээ байгуулсан биржийн гишүүн үнэт цаасны компани нь өөр өөрсдийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн зөрчил, хохирол, үр дагаврын хариуцлагыг хүлээнэ.

- 2.6. Зах зээл үүсгэгч нь зах зээл үүсгэгчээр бүртгүүлэхдээ дараах шалгуур, шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 2.6.1. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1 тэрбум төгрөгөөс доошгүй байх;
 - 2.6.2. Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, сонирхлын зөрчлийг зохицуулах дүрэм, журамтай байх;
 - 2.6.3. Зах зээл үүсгэгчээр бүртгүүлэх хүсэлт гаргахаас өмнөх 1 жилийн хугацаанд компани болон зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааг хариуцан ажиллах мэргэжилтэн нь үнэт цаасны зах зээлийг урвуулан ашигласан зөрчлийн хэрэгт хариуцлага хүлээж байгаагүй, Эрүүгийн хуульд заасан эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж, ял эдэлж байгаагүй байх;
 - 2.6.4. Хүсэлт гаргасан этгээд нь Биржийн гишүүн тохиолдолд “Гишүүнчлэлийн журам”-д заасан төлбөр, хураамжийн өргүй байх;
 - 2.6.5. Энэхүү журмын 2.1.3-д заасан этгээд дараах нэмэлт шаардлагыг хангана:
 - 2.6.5.1. өөрийн гишүүнчлэлтэй зохицуулалттай зах зээлд зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй, эсхүл зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа эрхэлж байсан туршлагатай байх;
 - 2.6.5.2. өөрийн харьяалагдах зохицуулалттай зах зээлийн дүрэм, журмыг зөрчсөний улмаас гишүүнчлэл, тусгай зөвшөөрөл нь цуцлагдаагүй, түдгэлзээгүй байх.

Гурав. Зах зээл үүсгэгчээр бүртгүүлэх

- 3.1. Зах зээл үүсгэгчээр бүртгүүлэх хүсэлтийг энэхүү журмын Хавсралт 1-т заасан бүрдүүлбэрийн хамт Биржид цахим эсхүл цаасан хэлбэрээр гаргана.
- 3.2. Зах зээл үүсгэгчээр бүртгэх эсэхийг журмын Хавсралт 1-т заасан баримт бичгийг бүрэн хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянан шийдвэрлэнэ.
- 3.3. Бирж зах зээл үүсгэгчээр бүртгүүлэх хүсэлтийг шийдвэрлэхтэй холбоотойгоор нэмэлт баримт, мэдээллийг шаардаж болно. Энэ тохиолдолд журмын 3.2-т заасан хугацааг нэг удаа ажлын 3 хүртэл өдрөөр сунгаж болно.
- 3.4. Бирж нь дараах тохиолдолд хүсэлт гаргагчийг зах зээл үүсгэгчээр бүртгэхээс татгалзана. Үүнд:
 - 3.4.1. Энэхүү журмын 2 дугаар бүлэгт заасан шалгуур, шаардлагуудыг хангаагүй;
 - 3.4.2. Хүсэлтэд хавсаргасан баримт материал бүрэн бус, алдаатай эсхүл хүчин төгөлдөр бус болох нь тогтоогдсон;
 - 3.4.3. Хүсэлтийг шалгаж байх хугацаанд хүсэлт гаргагчийн арилжаанд оролцох эрхийг хязгаарлах, гишүүний эрх эсхүл тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хасах зэрэг шийдвэр гарсан;
 - 3.4.4. Биржийн шаардсан нэмэлт баримт, мэдээллийг Биржээс тогтоосон хугацаанд ирүүлээгүй;
 - 3.4.5. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.
- 3.5. Бирж хүсэлт гаргагчийг зах зээл үүсгэгчээр бүртгэх бол Биржийн Гүйцэтгэх захирал тушаал гаргаж бүртгэн “Зах зээл үүсгэх гэрээ” байгуулна.
- 3.6. Хүсэлт гаргагч нь зах зээл үүсгэгчээр бүртгэгдсэний дараа үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанд зориулсан тусгайлсан данс нээлгэнэ.
- 3.7. Бирж нь хүсэлт гаргагчийг зах зээл үүсгэгчээр бүртгэхээс татгалзсан тохиолдолд албан бичгээр хариуг цахим эсхүл цаасан хэлбэрээр хүргүүлнэ.
- 3.8. Бирж нь үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор энэхүү журмын 2 дугаар бүлэгт заасан шаардлага хангасан этгээдтэй “Зах зээл үүсгэх гэрээ” байгуулж болно.

- 3.9. Бирж зах зээл үүсгэгчээр бүртгэсэн хуулийн этгээдийн жагсаалт, түүнд орсон өөрчлөлтийг өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

Дөрөв. Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа

- 4.1. Зах зээл үүсгэгч нь энэхүү журам болон биржээс тогтоосон нөхцөл шаардлагын дагуу зах зээл үүсгэх үйл ажиллагааг эрхэлнэ.
- 4.2. Зах зээл үүсгэгч нь дараах үүрэгтэй байна. Үүнд:
- 4.2.1. Зах зээл үүсгэх үйл ажиллагаанд зориулан үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өөрийн нэр дээр тусгайлан нээсэн данснаас бусад энгийн захиалгаас ялгагдахуйц тусгай тэмдэглэгээтэй арилжаанд оролцох;
- 4.2.2. Энэхүү журмын 2.6.2-т заасан дүрэм, журам, бодлогыг тогтмол хэрэгжүүлэх;
- 4.2.3. “Зах зээл үүсгэх гэрээ”-ний үүргийг тогтмол биелүүлэх;
- 4.2.4. Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанд сонирхлын зөрчил үүсгэхгүй байх;
- 4.2.5. Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанаас үүсэх үр дагаврыг бүрэн хариуцах, үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулах бол гэрээнд талуудын эрх, үүрэг, хариуцлагыг бүрэн тусгах, гэрээнд нэмэлт өөрчлөлт орсон, дуусгавар болгосон бол Биржид тухай бүр мэдэгдэж байх;
- 4.2.6. Энэхүү журмын 4.3-д заасан шаардлага, нөхцөлийг баримтлан үйл ажиллагаа явуулах;
- 4.2.7. Энэхүү журмын 2 дугаар бүлэгт заасан шалгуур, шаардлагатай холбоотой үйл ажиллагаанд гарсан өөрчлөлтийг Биржид ажлын 3 хоногийн дотор мэдэгдэх;
- 4.2.8. Зах зээл үүсгэгч нь өөрийн гаргасан үнэт цаасанд зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.
- 4.2.9. Үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулахгүйгээр аливаа үнэт цаасны зах зээл үүсгэх бол тус үнэт цаасны талаар Биржид урьдчилан бичгээр мэдэгдсэний үндсэн дээр зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа явуулна.
- 4.2.10. Энэ журмын 2.1.2, 2.1.3-т заасан этгээд нь нэмэлтээр дараах үүргийг хүлээнэ:
- 4.2.10.1. Энэ журмын 2.3-т заасны дагуу гэрээ байгуулсан үнэт цаасны компани, зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажилтан болон тусгайлсан дансанд өөрчлөлт орох тохиолдолд Биржид урьдчилан мэдэгдэнэ.
- 4.2.10.2. Энэ журмын 2.3-т заасны дагуу гэрээ байгуулсан үнэт цаасны компаниар дамжуулан арилжаанд оролцох боломжгүй болсон тохиолдолд Биржид нэн даруй мэдэгдэж, шинээр үнэт цаасны компанитай гэрээ байгуулах хүртэл хугацаанд зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 4.3. Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанд дараах нөхцөл, шаардлагыг баримтлах үүрэгтэй. Үүнд:
- 4.3.1. Арилжааны системд оруулах нэг удаагийн худалдах, худалдан авах захиалга тус бүрийн доод хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна:
- 4.3.1.1. Хувьцааны бүртгэлийн I ангиллын хувьцаа болон өрийн хэрэгсэл, ХБҮЦ, бусад санхүүгийн хэрэгсэл бол 300,000 төгрөгөөс доошгүй;
- 4.3.1.2. Хувьцааны бүртгэлийн II ангиллын хувьцаа болон сангийн нэгж эрх бол 150,000 төгрөгөөс доошгүй;
- 4.3.1.3. Хувьцааны бүртгэлийн III ангиллын хувьцаа бол 50,000 төгрөгөөс доошгүй.
- 4.3.2. Худалдах болон худалдан авах захиалгын үнийн саналыг тухайн үнэт цаасны сүүлийн ханшаас дараах хязгаарыг хүртэлх хүрээнд тогтооно. Үүнд:
- 4.3.2.1. Хувьцааны бүртгэлийн I ангиллын хувьцаа болон өрийн хэрэгсэл, ХБҮЦ, бусад санхүүгийн хэрэгсэл: 3%;
- 4.3.2.2. Хувьцааны бүртгэлийн II ангиллын хувьцаа болон сангийн нэгж эрх: 4%;
- 4.3.2.3. Хувьцааны бүртгэлийн III ангиллын хувьцаа: 5%.

- 4.3.3. Тухайн үнэт цаасны зах зээлийг үүсгэж эхэлсэн өдрөөс хойш арилжааны өдөр бүр энгийн арилжааны цагийн 50%-иас доошгүй хугацаанд зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
- 4.3.4. Журмын 4.3.3-т заасан зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа явуулсан хугацааг арилжааны системд оруулсан нийт захиалгуудын захиалгын санд байршсан нийт хугацааны нийлбэрээр гаргана. Ердийн арилжааны үед ханшийн хэт өөрчлөлтийн улмаас нээлтийн дахин дуудлага арилжаа явагдах тохиолдолд энгийн арилжааны цагаас дуудлага арилжаа явагдсан хугацааг хасаж, түүнээс зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа явуулах хугацааг тооцно.
- 4.3.5. Зах зээл үүсгэгч нь нэгээс дээш үнэт цаасны зах зээлийг үүсгэхээр бүртгүүлсэн тохиолдолд тухайн үнэт цаас бүрийн хувьд гүйцэтгэх зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа нь энэ бүлэгт заасан шаардлага, нөхцөлд нийцсэн байна.
- 4.3.6. Журмын 6 дугаар бүлэгт заасан нөхцөл байдал бий болсноос бусад тохиолдолд аливаа худалдах, худалдан авах захиалга биелэгдсэн, захиалга цуцлагдсан тохиолдолд худалдах, худалдан авах захиалгыг тогтмол шинэчилнэ. Аливаа захиалга биелэгдэж хэлцэл хийгдсэн, захиалгыг цуцалснаас хойш 5 минутын дотор дараагийн худалдах, худалдан авах захиалгыг оруулна. Захиалга хэсэгчлэн биелэгдсэн тохиолдолд хэсэгчлэн биелэгдсэнээс хойш 5 минутын дотор тухайн хэмжээгээр нэмж оруулна.
- 4.3.7. Арилжааны системд нэгэн зэрэг оруулж буй худалдах болон худалдан авах захиалгуудын хоорондын тоо ширхгийн зөрүү 50 хувиас ихгүй байна. Худалдах захиалгаас худалдан авах захиалгыг хасаж түүнийг худалдах болон худалдан авах захиалгын аль өндөр утгад хуваах замаар уг зөрүүг тооцоолно.
- 4.3.8. Зах зээл үүсгэгчийн арилжааны системд оруулсан худалдах, худалдан авах захиалга нь тухайн өдрөө биелэгдээгүй бол тухайн арилжааны өдрийн эцэст хүчингүй болно.
- 4.3.9. Зах зээл үүсгэгч нь нээлтийн дуудлага арилжаа дууссаны дараа захиалга оруулж болно.
- 4.3.10. Захиалгын санд ижил цаг хугацаанд байхаар оруулсан худалдах болон худалдан авах захиалгыг нэгэн зэрэг гаргасан захиалга гэж үзнэ.
- 4.4. Зах зээл үүсгэгч нь зах зээл үүсгэх үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг бусад захиалгын баримт материалаас тусгаарлан, захиалга болон хэлцэл бүрийг тодорхой тусгасан бүртгэлийг хөтөлж, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу хадгална.
- 4.5. Зах зээл үүсгэгчид үнэт цаасны үнийн хэт өндөр өсөлт, бууралтаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах нэрийн дор зах зээлийг урвуулан ашиглахыг хориглоно.
- 4.6. Зах зээл үүсгэгч нь үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр тухайн үнэт цаасны зах зээл үүсгэх ажиллагааг хэрэгжүүлж болно.
- 4.7. Зах зээл үүсгэгч нь үнэт цаас гаргагчтай “Зах зээл үүсгэх үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулсан тохиолдолд уг гэрээнд энэхүү журмын 4.3.1-4.3.3 болон 4.3.6-д зааснаас илүү хатуу шаардлага тогтоосон нөхцөлүүдийг тусгаж болох ба тэдгээр нөхцөлийг зах зээл үүсгэгчийн үүргийн хэрэгжилтийн үнэлгээнд ашиглана.
- 4.8. Зах зээл үүсгэгчийн тусгай дансанд байршсан хувьцааны тоо хэмжээ олон нийтэд чөлөөтэй арилжигддаг хувьцааны 5 ба түүнээс дээш хувьд хүрэх тохиолдолд нийтэд мэдээлнэ.

Тав. Зах зээл үүсгэх гэрээг түдгэлзүүлэх, цуцлах

- 5.1. Бирж нь дараах тохиолдлуудад зах зээл үүсгэгчтэй байгуулсан гэрээг түдгэлзүүлнэ. Үүнд:
 - 5.1.1. Зах зээл үүсгэгч нь Биржийн гишүүн үнэт цаасны компани тохиолдолд тухайн гишүүний арилжаанд оролцох эрхийг хязгаарласан, гишүүнчлэлийн эрх болон тусгай

зөвшөөрөл түдгэлзүүлсэн, энэхүү журмын 2.1.3-т заасан этгээд болон түүнтэй энэхүү журмын 2.3-т заасны дагуу гэрээ байгуулсан биржийн гишүүн үнэт цаасны компанийн гишүүнчлэлийн эрх болон тусгай зөвшөөрөл түдгэлзүүлсэн, 2.1.2-т заасан этгээдийн тусгай зөвшөөрөл түдгэлзүүлсэн;

- 5.1.2. Энэхүү журам, зах зээл үүсгэх гэрээ болон зах зээл үүсгэх үйлчилгээний гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, зөрчсөн;
- 5.1.3. Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан.
- 5.2. Энэхүү журмын 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.3-т заасан нөхцөл бий болсон даруй зах зээл үүсгэгчтэй байгуулсан гэрээг түдгэлзүүлсэнд тооцох ба зах зээл үүсгэгчид мэдэгдэнэ. Энэхүү журмын 5.1.2-т заасан үндэслэлээр гэрээг түдгэлзүүлэх бол Бирж зах зээл үүсгэгчид бичгээр мэдэгдэнэ.
- 5.3. Зах зээл үүсгэгч нь “Зах зээл үүсгэх гэрээ”-г цуцлах бол 30-аас доошгүй өдрийн өмнө Хавсралт 3 дахь маягтын дагуу гэрээ цуцлах хүсэлтээ Биржид гаргана.
- 5.4. Бирж нь дараах тохиолдлуудад зах зээл үүсгэгчтэй байгуулсан гэрээг цуцална. Үүнд:
 - 5.4.1. Зах зээл үүсгэгч энэхүү журамд заасан шалгуур, шаардлагыг хангахгүй болсон;
 - 5.4.2. Энэхүү журам болон биржтэй байгуулсан “Зах зээл үүсгэх гэрээ”-нд заасан үүргээ удаа дараа биелүүлээгүй, зөрчсөн;
 - 5.4.3. Дараалсан хоёр сарын хугацаанд, тухайн сар бүр дараалсан 5 ба түүнээс дээш өдөр энэхүү журмын 4.3-т заасан шаардлагыг баримтлаагүй тохиолдолд;
 - 5.4.4. Энэхүү журмын 2.1.1-т заасан этгээдийн хувьд Биржийн гишүүнчлэлээс, 2.1.3-т заасан этгээдийн хувьд өөрийн харьяалагдах зохицуулалттай зах зээлийн гишүүнчлэлээс хасагдсан эсхүл тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан, 2.1.2-т заасан этгээдийн хувьд тусгай зөвшөөрөл цуцлагдсан;
 - 5.4.5. Журмын 2.1.2, 2.1.3-т заасан Зах зээл үүсгэгч гишүүн үнэт цаасны компанитай байгуулсан гэрээг дуусгавар болгосон боловч ажлын 10 өдрийн дотор шинээр байгуулж, Биржид мэдэгдээгүй;
 - 5.4.6. Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан.
- 5.5. Бирж нь энэхүү журмын 5.4-т заасны дагуу гэрээг цуцалсан тохиолдолд үндэслэлийг зах зээл үүсгэгчид бичгээр мэдэгдэнэ.

Зургаа. Онцгой нөхцөл байдал

- 6.1. Зах зээл үүсгэгч нь дараах тохиолдлуудад энэхүү журамд заасан үүргээс чөлөөлөгдөж болно. Үүнд:
 - 6.1.1. Ханшийн хэт хэлбэлзэл: Тухайн үнэт цаасны ангиллын индекс, ангиллын индекс байхгүй бол Биржийн ТОП-20 индекс сүүлийн нэг сарын хугацаанд 30 ба түүнээс дээш хувиар өөрчлөгдсөн;
 - 6.1.2. Давагдашгүй хүчин зүйлд өртсөнөөс энэхүү журамд заасан үүргээ биелүүлэх боломжгүй болсон;
 - 6.1.3. Биржийн арилжааны системд ноцтой гэмтэл, саатал үүссэн;
 - 6.1.4. Үнэт цаас гаргагч холбогдох журмын дагуу үнэт цаасны үнэ, ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлж болох мэдээллийг нийтэд ил болгосон;
 - 6.1.5. Зах зээл үүсгэх үнэт цаасны арилжааг зогсоосон.
- 6.2. Дараах тохиолдолд зах зээл үүсгэгчийн худалдах, худалдан авах захиалгын үнийн зөрүүг энэхүү журмын 4.3.2-т заасан хэмжээнээс 2 дахин нэмэгдүүлэх, захиалгын доод хэмжээг 2 дахин бууруулах хөнгөлөлтийг үзүүлж болно. Үүнд:
 - 6.2.1. Тухайн үнэт цаасны ангиллын индекс, ангиллын индекс байхгүй бол Биржийн ТОП-20 индекс 10-аас дээш хувиар хэлбэлзэж эхэлбэл тухайн өдөртөө болон арилжааны дараагийн өдөрт;

- 6.2.2. Энэхүү журмын 6.1.4-д заасан нөхцөл;
6.2.3. Биржээс зөвшөөрсөн бусад тохиолдол.
- 6.3. Зах зээл үүсгэгч нь энэхүү журмын 6.1.1, 6.1.4, 6.2.1-6.2.3-т заасан үндэслэлээр зах зээл үүсгэгчийн үүргээс чөлөөлөгдөх, хөнгөлөгдөх бол Биржид урьдчилан хүсэлт гаргана.
- 6.4. Зах зээл үүсгэгч нь энэхүү журмын 6.1.2-т заасан үндэслэлээр зах зээл үүсгэгчийн үүргээс чөлөөлөгдөх бол давагдашгүй хүчин зүйлд өртсөн тухай тайлбар, баримтыг тус хүчин зүйл бий болсноос хойш ажлын 2 өдөрт багтаан Биржид хүргүүлнэ.
- 6.5. Бирж өөрийн санаачилгаар эсхүл энэхүү журмын 6.3-т заасан зах зээл үүсгэгчийн хүсэлтэд үндэслэн онцгой нөхцөл байдал үүссэн бол өөрийн цахим хуудсаар нийтэд мэдээлж, энэ тухай мэдэгдлийг системээр дамжуулан зах зээл үүсгэгчдэд мэдэгдэнэ.
- 6.6. Бирж энэхүү журмын 6.1.1 болон 6.1.4-д заасан онцгой нөхцөл байдлын үргэлжлэх хугацааг өөрөөр шийдвэрлэхээс бусад тохиолдолд уг хугацаа нь тухайн арилжааны өдрийн энгийн арилжааны үе дуусах хүртэл үргэлжилнэ.
- 6.7. Бирж онцгой нөхцөл байдал дуусаж, энгийн арилжаа үргэлжилж эхэлсэн талаар өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

Долоо. Зах зээл үүсгэгчийн үүргийн хэрэгжилтийг үнэлэх, арилжааны шимтгэлийн хөнгөлөлт олгох

- 7.1. Бирж зах зээл үүсгэгчийн үүргийн хэрэгжилтэд үндэслэн арилжааны шимтгэлийн хөнгөлөлт олгож болно.
- 7.2. Бирж нь зах зээл үүсгэгчийн үүргийн хэрэгжилтийг дараах шалгуурын дагуу үнэлнэ:
7.2.1 Энэхүү журмын 4.3.1-д заасан худалдах, худалдан авах захиалгын доод хэмжээг баримталсан байдал;
7.2.2 Энэхүү журмын 4.3.2-д заасан худалдах болон худалдан авах захиалгын тогтоосон үнийн зөрүүг баримталсан байдал;
7.2.3 Энэхүү журмын 4.3.3-д заасны дагуу арилжаанд оролцсон байдал;
7.2.4 Энэхүү журам болон Бирж, үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлсэн байдал.
- 7.3. Зах зээл үүсгэгчийн зах зээл үүсгэх үйл ажиллагаанд хамаарах арилжааны шимтгэлийг 100 хувь хөнгөлнө.
/Энэхүү заалтыг 2029 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө./
- 7.4. Зах зээл үүсгэгчийн үүргийн хэрэгжилт тухайн зах зээл үүсгэж буй үнэт цаасны хувьд 80 ба түүнээс дээш хувиар үнэлэгдсэн тохиолдолд зах зээл үүсгэх үйл ажиллагааны хүрээнд хийсэн арилжааны шимтгэлийг 100 хувь хөнгөлнө. Үүргийн хэрэгжилт 80-аас доош хувиар үнэлэгдсэн тохиолдолд арилжааны шимтгэлийн хөнгөлөлт олгохгүй.
/Энэхүү заалтыг 2029 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./
- 7.5. Зах зээл үүсгэгчийн тухайн сарын гэрээний үүргийн хэрэгжилтийг журмын Хавсралт 4-т заасан аргачлалын дагуу сар тутам үнэлнэ.
- 7.6. Бирж нь зах зээл үүсгэгчийн тухайн сарын хугацаанд үүсгэсэн зах зээлийн мэдээллийг үнэт цаас тус бүрээр гарган дараа сарын эхний 10 өдөрт багтаан зах зээл үүсгэгчид хүргүүлнэ.
- 7.7. Энэхүү журмын 7.2.3-т заасны дагуу арилжаанд оролцсон байдлыг үнэлэхдээ тухайн үнэт цаасыг арилжааны өдрийн энгийн арилжааны үед арилжих боломжтой байсан эсэх буюу тухайн үнэт цаасны арилжигдсан нийт хугацааг харгалзан үзнэ.
- 7.8. Бирж нь зах зээл үүсгэгчийн үүргийн хэрэгжилтийг гаргах, арилжааны шимтгэлийн хөнгөлөлтийг олгохтой холбоотойгоор зах зээл үүсгэгчээс баримт, мэдээллийг хугацаан тогтоон шаардан авах эрхтэй байна.
- 7.9. Зах зээл үүсгэгч 7.8-д заасан баримт, мэдээллийг Биржид тогтоосон хугацаанд ирүүлээгүй тохиолдолд арилжааны шимтгэлийн хөнгөлөлт олгохгүй.

7.10. Зах зээл үүсгэгчид мэдээлэл нийлүүлэх үйлчилгээг зөвхөн зах зээл үүсгэх үйл ажиллагаанд ашиглах нөхцөлөөр, тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх хугацаанд үнэ төлбөргүй үзүүлнэ.

Найм. Хариуцлага

- 8.1. Биржийн хяналт, шалгалт хариуцсан нэгж “Хяналт шалгалтын журам”-д заасан үндэслэл, чиглэлийн дагуу зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанд зайн болон газар дээрх хяналт, шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулна.
- 8.2. Зах зээл үүсгэгч нь энэхүү журам болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд “Хяналт шалгалтын журам”-д заасан хариуцлага хүлээлгэхээс гадна дараах арга хэмжээг авч болно.
 - 8.2.1. Зах зээл үүсгэгчид олгосон арилжааны шимтгэлийн хөнгөлөлтийг буцаан төлүүлэх;
 - 8.2.2. Зах зээл үүсгэгчтэй байгуулсан гэрээг түдгэлзүүлэх;
 - 8.2.3. Зах зээл үүсгэгчтэй байгуулсан гэрээг цуцлах.
- 8.3. Бирж нь зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, зах зээлийг урвуулан ашиглах замаар үнэ ханшийг зохиомлоор тогтоосныг илрүүлэх, зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлэх ба зах зээлийг урвуулан ашигласан нь тогтоогдсон тохиолдолд холбогдох арга хэмжээг авч, хуулийн хариуцлага хүлээлгэх талаар холбогдох дүгнэлт, тайланг тухай бүр Хороонд хүргүүлнэ.

---oO---

“Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам”-ын

Хавсралт 1

Зах зээл үүсгэгчээр бүртгүүлэх хүсэлтэд тусгах мэдээлэл, бүрдүүлэх материал

№	Мэдээлэл, баримтын төрөл	
1	Хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл, үйл ажиллагааны зөвшөөрөл, гэрчилгээ, дүрэм	
2	ХОС бол эрх бүхий байгууллагын шийдвэр <i>Энэ хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 22 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./</i>	
3	Биржийн гишүүн үнэт цаасны компанийн хувьд Дилерээр ажиллах мэргэжилтний мэдээлэл. Үүнд МХБ-ийн "Гишүүнчлэлийн журам"-ын хавсралт 2-ын дагуу боловсон хүчний тодорхойлолтыг ирүүлэх; ХОС болон гадаадын зохицуулалттай этгээд бол энэхүү журмын 2.3-т заасны дагуу биржийн гишүүн үнэт цаасны компанийн ажилтан болон зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэх ажилтны дээрх мэдээллийг адил ирүүлнэ <i>Энэ хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 22 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./</i>	
4	Арилжаанд оролцох систем, программ хангамжийн мэдээлэл, танилцуулга	
5	Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, сонирхлын зөрчлийг зохицуулсан журам	
6	Хууль тогтоомж чанд мөрдөн ажиллах тухай гаргасан батламж	
7	Зах зээл үүсгэх үнэт цаасны нэр, ISIN, төрөл, эзэмшиж буй тоо хэмжээ; Тухайн үнэт цаас гаргагчтай бизнесийн болон бусад холбоо хамааралтай эсэх талаар тайлбар, үнэт цаас гаргагчид үзүүлсэн эсхүл үзүүлэх үйлчилгээнүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл, баримт	
8	Үнэт цаас гаргагчтай байгуулах "Зах зээл үүсгэх үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний төсөл. (Үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулахгүйгээр зах зээл үүсгэх тохиолдолд уг гэрээний төсөл шаардлагагүй)	
9	"Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам"-ын 2.6-д заасныг нотлох баримтууд	
10	Өргөдөлтэй холбоотойгоор харилцах этгээдийн нэр, холбоо барих мэдээлэл	
11	Энэхүү журмын 2.3-т заасан үнэт цаасны компанитай байгуулсан гэрээний төсөл	
12	Биржээс шаардлагатай гэж үзсэн бусад баримт материалууд	

---o0o---

Зах зээл үүсгэх гэрээ

20... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас "Монголын хөрөнгийн бирж" ХК (цаашид "Бирж" гэх), түүнийг төлөөлж, нөгөө талаас "..... ҮЦК" ХХК (цаашид "Зах зээл үүсгэгч", хамтад нь "Талууд" гэх)-ийг төлөөлж нар Биржийн "Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам"-ын 3.5-д заасныг үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү гэрээгээр Биржид зах зээл үүсгэгчээр бүртгүүлсэн этгээдийн зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага болон тус үйл ажиллагаатай холбоотойгоор талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.
- 1.2. Зах зээл үүсгэгч нь ХОС, эсхүл Хорооноос баталсан жагсаалтад багтсан гадаадын биржийн гишүүн хуулийн этгээд бол зах зээл үүсгэгчийн захиалгыг зөвхөн Биржийн гишүүн үнэт цаасны компаниар дамжуулан арилжааны системд оруулна.
/Энэ хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 22 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./
- 1.3. Талуудын хооронд үүсэх энэхүү гэрээгээр зохицуулаагүй харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "Хороо" гэх), Биржийн журам, заавраар зохицуулна.
- 1.4. Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгч гэрээнд гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээний хугацаа 1 жил байна.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1. Гэрээний хугацаа 20... оны ... сарын ...-ны өдрөөс 20... оны ... сарын ...-ны өдрийг хүртэл 1 жил байна.
- 2.2. Зах зээл үүсгэгч нь гэрээ дуусгавар болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө гэрээ сунгах тухай хүсэлтээ Биржид албан бичгээр ирүүлнэ.
- 2.3. Бирж нь 2.2-т заасан хүсэлтийн дагуу Зах зээл үүсгэгч нь "Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам"-ын 2 дугаар бүлэгт заасан шалгуур, шаардлагыг хангаж байгаа эсэхийг нягтлан, гэрээний биелэлтийг дүгнэн, гэрээний үүргийн хэрэгжилт 50 ба түүнээс дээш хувиар дүгнэгдсэн тохиолдолд гэрээг дахин 1 жилээр сунгана.

Гурав. Талуудын эрх, үүрэг

- 3.1. Бирж дараах эрх эдэлнэ. Үүнд:
 - 3.1.1. Зах зээл үүсгэгчийг хууль, дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүрэг болон Биржээс гаргасан шийдвэрийг биелүүлэхийг шаардах;
 - 3.1.2. Зах зээл үүсгэгчийг Биржийн цахим хуудас дахь зах зээл үүсгэгчийн жагсаалтад оруулах, гэрээ дуусгавар болсон тохиолдолд жагсаалтаас хасах;
 - 3.1.3. Зах зээл үүсгэгчийн зах зээл үүсгэж буй үнэт цаасны мэдээллийг цахим хуудастаа тухай бүр, нээлттэй байршуулах;

- 3.1.4. Зах зээл үүсгэгч нь зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох журамд заасан арга хэмжээг авах;
- 3.1.5. Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа, үүргийн хэрэгжилтийг үнэлж, арилжааны шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх эсэхийг шийдвэрлэх;
- 3.2. Бирж дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 3.2.1. Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанд холбогдох журмын дагуу хяналт тавих;
 - 3.2.2. Зах зээл үүсгэгчийн гэрээний үүргийн хэрэгжилтийг сар бүр үнэлэх;
 - 3.2.3. “Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам”-д заасан нөхцөл хангагдсан тохиолдолд арилжааны шимтгэлийн хөнгөлөлтийг олгох;
 - 3.2.4. Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаатай холбогдуулан арилжааны системд орж болох өөрчлөлтийн талаар урьдчилан мэдэгдэх;
 - 3.2.5. Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журамд нэмэлт, өөрчлөлт орсон, шинэчлэн баталсан бол цахим хуудаастаа байршуулах байдлаар мэдэгдэх;
- 3.3. Зах зээл үүсгэгч нь дараах эрх эдэлнэ. Үүнд:
 - 3.3.1. “Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу үнэт цаасны арилжааны шимтгэлийн хөнгөлөлтөд хамрагдах эрхтэй;
 - 3.3.2. “Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлд заасан онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд зах зээл үүсгэгчийн үүргээс чөлөөлөгдөж болно;
 - 3.3.3. “Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам”-д заасан нөхцөлд зах зээл үүсгэгчийн худалдах, худалдан авах захиалгын үнийн зөрүүг журамд заасан хэмжээнээс 2 дахин нэмэгдүүлэх, захиалгын доод хэмжээг 2 дахин бууруулж болно.
 - 3.3.4. Зах зээл үүсгэгчийн тухайн сарын үүргийн хэрэгжилтийн үнэлгээтэй танилцах, шаардлагатай тохиолдолд холбогдох тайлбарыг авах.
- 3.4. Зах зээл үүсгэгч нь Биржийн “Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам”-д зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ.
 - 3.4.1. Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журамд заасан нөхцөл, шаардлага болон үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээнд нийцүүлэн зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааг гүйцэтгэх;
 - 3.4.2. Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанд зах зээлийг урвуулан ашиглах аливаа үйлдэл, зөрчил гаргахгүй байх;
 - 3.4.3. Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, сонирхлын зөрчлийг зохицуулсан журмыг шаардлагатай тохиолдолд тухай бүр шинэчилж, сайжруулж байх, журмын өөрчлөлтийг тухай бүр Биржид мэдэгдэх;
 - 3.4.4. Дилерээр ажиллах мэргэжилтний мэдээлэл өөрчлөгдөх тохиолдолд урьдчилан Биржид мэдэгдэж, бүртгүүлэх;
 - 3.4.5. Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанаас шууд эсхүл шууд бусаар Бирж эсхүл гуравдагч этгээдэд учруулсан хохирол буюу алдагдлыг бүрэн хариуцах, төлөх.

Дөрөв. Зах зээл үүсгэгчийн үүргийн хэрэгжилтийг дүгнэх, арилжааны шимтгэлийн хөнгөлөлт олгох

- 4.1. Бирж нь “Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу зах зээл үүсгэгчийн үүргийн хэрэгжилтийг үнэлнэ.
- 4.2. Зах зээл үүсгэж буй үнэт цаасны арилжааны шимтгэлийг “Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу хөнгөлнө.
- 4.3. Бирж зах зээл үүсгэгчийн үүргийн хэрэгжилтийг дүгнэж, түүнд олгох арилжааны шимтгэлийн хөнгөлөлтийг зах зээл үүсгэгчид шилжүүлнэ.

Тав. Гэрээг түдгэлзүүлэх, дуусгавар болгох

- 5.1. Энэхүү гэрээг Биржийн “Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам”-д заасан үндэслэлээр түдгэлзүүлэх болон дуусгавар болгоно.
- 5.2. “Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам”-д зааснаар энэхүү гэрээг түдгэлзүүлсэн, цуцалсан тохиолдолд Зах зээл үүсгэгч нь зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй.

Зургаа. Бусад

- 6.1. Энэхүү гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.
- 6.2. Холбогдох харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд эсхүл талуудын хүсэлтээр харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба энэ тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулна.
- 6.3. Гэрээний асуудлаар маргаан үүссэн тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Тохиролцоонд эс хүрвэл асуудлыг Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.4. Энэхүү гэрээний болон Биржийн баталсан дүрэм, журмын заалт хоорондоо зөрвөл Биржийн баталсан дүрэм, журмын заалтыг баримтална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

ЗАХ ЗЭЭЛ ҮҮСГЭГЧ “.....”
ХК/ХХК -ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

---o0o---

“Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам”-ын

Хавсралт 3

Зах зээл үүсгэх гэрээ цуцлах өргөдлийн маягт

Зах зээл үүсгэгчийн нэр	
Биржид бүртгэлтэй хаяг	

Биржийн “Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар бүлэгт заасны дагуу Биржтэй байгуулсан “Зах зээл үүсгэх гэрээ”-г цуцлах хүсэлтэй ба дараах үнэт цаасны зах зээл үүсгэх ажиллагааг зогсоох хүсэлтийг гаргаж байна.

№	Үнэт цаасны ISIN, Символ	Он, сар, өдөр
1		
2		
3		

Бид энэхүү өргөдөлд заасан өдөр хүртэл, зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааг явуулна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

---ооо---

Зах зээл үүсгэгчийн үүргийн хэрэгжилтийг үнэлэх аргачлал

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. “Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам” (цаашид “Журам” гэх)-ын дагуу зах зээл үүсгэгчийн үүргийн хэрэгжилтийг энэхүү аргачлалд заасны дагуу үнэлнэ.
- 1.2. Үүргийн хэрэгжилтийг шалгуур тус бүрээр биелэлтийн хувь (%)–аар тодорхойлж, тухайн шалгуурт оноосон жингээр үржүүлэн жинлэсэн оноог тооцно.
- 1.3. Нийт оноог шалгуур тус бүрийн жинлэсэн онооны нийлбэрээр тодорхойлно.

Хоёр. Үнэлгээнд хамруулахгүй нөхцөл

- 2.1. Үнэлгээний хугацаанд дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн үнэт цаасанд үүргийн хэрэгжилтийн оноо тооцохгүй бөгөөд арилжааны шимтгэлийн хөнгөлөлт олгохгүй:
 - 2.1.1. Зах зээлийг урвуулан ашигласан нь тогтоогдсон;
 - 2.1.2. Биржийн хяналт, шалгалтад болон тайлбар, тодруулга, мэдээлэл хүсэхэд хамтран ажиллаагүй;
 - 2.1.3. Тайлан мэдээг тогтоосон хугацаанд ирүүлээгүй.

Гурав. Үнэлгээ хийх зарчим

- 3.1. Зах зээл үүсгэгчийн үүргийн хэрэгжилтийг 0-100 оноогоор үнэлнэ.
- 3.2. Шалгуур тус бүрийн биелэлт, хэрэгжилтийг зах зээл үүсгэгчийн Биржид ирүүлсэн тайлан мэдээ болон үнэлгээний хугацаанд биржийн арилжааны системд бүртгэгдсэн захиалга, гүйцэтгэсэн хэлцлийн мэдээлэлд үндэслэн тооцно.
- 3.3. Үүргийн хэрэгжилтийн үнэлгээг сар тутам хийж, дүгнэнэ. Гишүүний зах зээл үүсгэж эхэлсэн хугацаанаас үл хамааран тухайн сарын үнэлгээг дараа сарын 10-ны өдрийн дотор хийнэ.
- 3.4. “Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам”-ын дагуу зах зээл үүсгэгчийн үүргээс чөлөөлөгдөх, хөнгөлөгдөх нөхцөл байдал үүсэн бол тус нөхцөл байдлыг үнэлгээ тооцохдоо авч үзнэ.
- 3.5. Бирж нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас зах зээл үүсгэгч бүрээр дансны хуулгыг сар бүрийн эхний 7 хоногоос хэтрэхгүй хугацаанд хүлээн авна.

Дөрөв. Үүргийн хэрэгжилтийн оноонд үндэслэн хөнгөлөлт олгох

- 4.1. Зах зээл үүсгэгчийн тухайн үнэт цаасанд зах зээл үүсгэх үйл ажиллагааны үүргийн хэрэгжилтийн нийт оноо 80 болон түүнээс дээш бол “Хангалттай биелүүлсэн” гэж үзэж, тухайн үнэт цаасанд хамаарах зах зээл үүсгэх үйл ажиллагааны арилжааны шимтгэлийг 100 хувь хөнгөлнө.
- 4.2. Үүргийн хэрэгжилтийн нийт оноо 80-аас доош бол “Хангалтгүй биелүүлсэн” гэж үзэж, тухайн үнэт цаасанд зах зээл үүсгэх үйл ажиллагааны арилжааны шимтгэлийн хөнгөлөлт олгохгүй.

Тав. Үүргийн хэрэгжилтийн үнэлгээний шалгуур

- 5.1. Зах зээл үүсгэгчийн тухайн сарын үүргийн хэрэгжилтийг дараах шалгуур, үзүүлэлтээр тооцно. Үүнд:

№	Үндсэн шалгуур шаардлага	Биелэлтийг хэмжих үзүүлэлт	Жин	Жинлэсэн оноо
1	Захиалгын доод хэмжээг баримталсан байдал	Шаардлага хангасан захиалга байршуулсан хугацааны хувь (%)	25	—
2	Захиалгын үнийн саналыг баримталсан байдал	Тогтоосон үнийн зөрүүний (spread) шаардлагыг хангасан хугацааны хувь (%)	25	—
3	Энгийн арилжаанд оролцсон байдал	Энгийн арилжааны үеэр оролцсон хугацааны (%)	25	—
4	Захиалга хоорондын тоо хэмжээний зөрүү	Худалдан авах, худалдах захиалгын хэмжээний зөрүү зөвшөөрөгдөх хязгаарт багтсан хугацааны хувь (%)	15	—
5	Тайлагнал	Тайлан мэдээг хугацаанд нь бүрэн ирүүлсэн хувь (%)	10	—
	Нийт	—	100	___/100

5.2. Зах зээл үүсгэгчийн үнэт цаас гаргагчтай байгуулсан “Зах зээл үүсгэгчийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-нд Журамд зааснаас илүү хатуу шаардлага тогтоосон нөхцөлүүдийг тусгасан бол тэдгээр нөхцөлийг зах зээл үүсгэгчийн үүргийн хэрэгжилтийн үнэлгээнд ашиглана.

Зургаа. Оноо тооцох аргачлал

- 6.1. Шалгуур тус бүрийн жинлэсэн оноог дараах байдлаар тооцно: Жинлэсэн оноо = Биелэлтийн хувь (%) × Жин
- 6.2. Нийт оноог дараах байдлаар тодорхойлно: Нийт оноо = Σ (шалгуур тус бүрийн жинлэсэн оноо)

Долоо. Бусад

- 7.1. Биржийн Хяналт шинжилгээний алба нь энэхүү аргачлалд заасны дагуу зах зээл үүсгэгчийн үүргийн хэрэгжилтийн үнэлгээ, тайланг сар бүр боловруулж зах зээл үүсгэгчид хүргүүлэх ба энэхүү аргачлалын хэрэгжилтийг хариуцаж ажиллана.
- 7.2. Бирж нь энэ аргачлалд заасны дагуу хийсэн зах зээл үүсгэгчийн үүргийн хэрэгжилтийн үнэлгээг зах зээл үүсгэж буй үнэт цаас бүрээр гарган Гишүүнд цахим шуудангаар хүргүүлнэ.
- 7.3. Шаардлагатай тохиолдолд Бирж үнэлгээний аргачлалд нэмэлт тодруулга, тайлбар гаргаж болно.

---o0o---